


АШУУИСийн Захирлын 2014 оны
12 дугаар сарын 11.-ний өдрийн
А/26
төөт тушаалын Тхавсралт



Ёс зүйн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү дүрмийн зорилго нь АШУУИС-ийн Эрхэм зорилго, эрхэмлэх үнэт зүйлсэд тулгуурлан сургуулийн хамт олны эрхэмлэх ёс суртахууны үнэт зүйлс, баримтлах ёс суртахууны зарчим, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож хэвшүүлэх, ёс суртахууны зөрчил гаргагчид хариушлага хүлээлгэх, сургуулийн соёлыг хүчтэй болгож бэхжүүлэхэд оршино.

1.1. АШУУИС-ийн хамт олны эрхэмлэх ёс суртахууны үнэт зүйлс нь :

- Хүний эрх, эрх чөлөө;
- Хүний үнэ цэнэ, үнэ хүнд;
- Ёс жудаг;
- Шударга ёс, зарчимч чанар;
- Адил тэгш хандлага, харилцаа зэрэг болно.

1.2. АШУУИС-ийн хамт олны баримтлах ёс суртахууны нийтлэг зарчим нь :

- Нийгэм, сургууль хамт олон, суралцагчад үзэнч байх;
- Ажил үүргээ хариушлагатай, найдвартай гүйцэтгэх, ходолморч байх;
- Үйл ажиллагаагаа хүчтэг энэрэнгүйгээр явуулах;
- Мэргжилдээ няйтг нямбай хандах;
- Хамтаг үзлийг эрхэмлэж, хамтын шийдвэрийг илүүд үзэх;
- Сургуулийн өмч хоронгол аривч хямгач хандах зэрэг болно.

1.3. АШУУИС-ийн хамт олны баримтлах ёс зүйн дүрмүүд

- "Их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн еренхий дүрэм
- АШУУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- АШУУИС-ийн Ёс зүйн хэм хэмжээ
- АШУУИС-ийн бүрэлдэхүүний сургууль, салбар сургуулийн Багшийн ёс зүйн дүрэм
- ЭМШУУИС-ийн Оюутны ёс зүйн дүрэм, бусад оюутны ёс зүйтэй холбоотой дүрэм
- "Эмнэлгийн мэргэжилтийн ёс зүйн хэм хэмжээ"

Хоёр. АШУУИС-ийн нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ

АШУУИС-д ажиллаж, суралцаж буй хүн бүхэн дагаж мөрдвөл зохих, тодорхой үйлдэл, эс үйлдлийг үүрэг болгосон, эсвэл хориглосон, бүгдэд адил тэгш үйлчлэх, тусгай хэм хэмжээгээр давхар баталгаажих, еренхий шинжктэй ёс суртахууны хэм хэмжээг нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ гэж үзнэ.

2.1. Нийтээр дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ нь:

1. Эрдэм мэдлэг, оюунлаг зүйлсийг эрхэмлэж, тэдгээрийг бусад эрх ашиг, сонирхлоос ямагт дээгүүрт тавих;
2. Ёс суртахууныг эрхэмлэх, ёс жудагтай биэз авч явах, орчин тойрныхоо хумүүст зүй ёсны шаардлага тавих, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхэд хувь нэмэрэе оруулах;
3. Яс үндэс, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарал, байдал, гэр бүлийн байдал, эрүүл мэндийн байдал, гадаад үзэмж, бэлгийн хандлага, нутаг ус, танил тал, төгссөн сургууль, нам эвсэл, бүлэглэл, үзэл бодол, байр суурь зэрэг аливаа шинжээр хэнийг боловч ялгаварлахгүй, адил тэгш хандах;

4. Үнэнч, шударга, зарчимч, хариуцлагатай байх, хүмүүс хоорондын эвгүй, сөрөг харилцаа, зөрчлөөс ангид ажиллах, суралцах;
5. Санал өгөх, шийдвэр гаргахдаа ил тод, бодитой, шударга, хүлээнтэй, буурь суурьтай хандах, өөрийгөө захирдаг байх;
6. Эрх мэдлээ урвуулан ашиглах, бусдыг хууран мэхлэх, залилах, залилангийн шинжтэй үйлдэл гаргахгүй байх;
7. Албан тушаал болон эрх мэдлээ ашиглан шууд болон шууд бусаар бэлгийн дарамт учруулах, зүй бус үт хэрэглэх, үйлдэл гаргах, сургалтын дүн болон бусад хүчин зүйлээр барьшаалан сэтгэл санааны дарамт учруулахгүй байх;
8. Цахим хуудас болон олон нийтийн мэдлээ мэдээллийн хэрэгсэл ашиглан буруу ташаа мэдлээ мэдээлэл цацах, бусдыг гүтгэх, ёс зүйтгүй хэллэг ашиглах.

2.2. Сургуулийн орчинд дараах зорчлүүдийг ёс суртахууны нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг гажуудуулсанд тооцино. Үүнд:

1. Оногдсон үүрэг даалгаврыг хугацаанд нь эс билүүлэх, үр ашиггүй зүйлд цаг, хөдөлморөө үрэх;
2. Санаатай, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдээр сургуулийн емч хөрөнгийг звдэж гэмтээх, устах, хулгайлах, дур мэдэн ашиглах, эзэмшилдээ авах, зориулалтын бусаар ашиглах, шамшигдуулах;
3. Согтууруулах, мансууруулах ундаа, эм, бодис хэрэглэх, согтуурсан, мансуурсан байдалтай нэвтрэх;
4. Бусдыг хилсээр буруутгах;
5. Мэдээллийг гүйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээлэх, цохилдуулах;
6. Бусдын хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцох, хувь хүний талаар зориуд сорог үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах;
7. Бүдүүлэг авирлах, хараалын үг хэрэглэх, үг хэлээр дайрч доромжлох, айлан сүрдүүлэх, дарамтлах;
8. Өөрийн үзэл бодол, байр суурийг зөвтөхийн төлөө бусдын үзэл бодол, байр суурийг мушгин гүйвуулах, гутаан доромжлох, гүтгэх зорог

Гурав. Багшийн дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ

3.1. Сургалтын ажлын хүрээнд, АШУҮИС-ийн Багши мэргэжлийн ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мөрднө:

1. Мэргэжлийн мэдлэг, чадвар, заах арга баршиа байшиг дээшлүүлэх;
2. Хичээлийн мэргэжлийн ондёр түвшинд зохион байгуулж, хичээлийн цагийг үр өгөөжтэй өнгөрүүлэх, заах арга, хичээлийн агуулгыг байнга боловсронгуй болгож байх;
3. Хичээлийн хетэлбэр, талевлэгэв, цаг, хуваарийг чанд баримтлах;
4. Суралцагчийн идэвхи санаачлагыг орнуулэх, суралын талааэх эрэл хайгуулыг дэмжих, хичээл, сургалттай холбоотой мэдээ, мэдээлэл олж авах боломж, эрүүл, аюулгүй, сэтгэл хангалиун суралцах орчин бүрдүүлэх;
5. Суралцагчдад бие дааж ажиллах чадвар эзэмшигүүлэх, бие дааж гүйцэтгэх ажлыг оюутны боломж, хичээлийн хетэлбөрийн түвшинд нийцүүлэх, ажлын чиглэл, агуулга, ашиглах мэдээллийн эх сурвалжийг тодорхой байлгах;
6. Суралцагчийн бие дааж болон багаар гүйцэтгэсэн ажлыг цаг тухайд нь шалгах, дүгнэх, үнэлэх, үр дүнг мэдээлэх, тайлгах;
7. Суралцагчид зөвлөгөө өгөх хуваарийг чанд баримтлах;
8. Суралцагч нэг бүрийн мэдлэг, чадварыг шалгах, дүгнэх, үнэлэх, тодорхойлоходо шударга, алагчлахгүй, адил тэгш, бодитой хандах, албаны болон хувийн харилцааг зааглах;

3.2. Сургалтын ажлын хүрээнд, АШУҮИС-ийн Багшийг ёс суртахууны зорчил гаргасанд тооцож, хариуцлага тооцох үндэслэл болох тохиолдлууд:

1. Суралцагчийг нас, хүйс, үндэс угсаа, хэл яриа, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, өнгө үзэмж, шашин шүүлэг, үзэл бодол, бие бялдар, эрүүл мэндийн байдал зэрэг аливаа байдлаар ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах;

- Суралцагчийг хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл, сургалт, бусад арга хэмжээнд оролцуулахгүй, оруулахгүй байх, хичээлээс гаргах;
- Хичээлд холбогдолгүй материал ихээр ашиглах;
- Багш өөрөө хүндэтгэх шалтгаангүйгээр хичээлээс хоцрох, хичээл таслах, суралцагчдыг цагаас өмнө тараах, хичээлийн цагаар танхимыг орхих, гар утсаар ярих зөргээр ажлын цагийг зүй бусаар өнгөрүүлэх;
- Хичээл, шалгалт, ажлын хуваарийг зөрчих, хичээл, шалгалтын хугацааг шалтгаангүйгээр өөрчлөх, хойшуулах;
- Суралцагчид хичээлийн гарын авлага, ном сурах бичиг зэргийг хүчээр, багшийн албан тушаал, эрхэлж буй ажил үүргээ хувийн зорилгоор ашиглан тулган зарж борлуулах;
- Суралцагчийн дүнг хуурамчаар тавих, мэдлэг чадварыг нь тухайн хичээлд хамааралгүй шалгуураар үнэлж дүгнэх, галны нөлөөлэлд автах, засварлах;
- Суралцагчийн суралцах үйл ажиллагааны үр дүнг үнэлэхийг шалтгаангүйгээр, толорхой бус хугацаагаар дур мэдэн хойшуулах, тайлан мэдээг хоцроо;
- Албан тушаал, эрх мэдлээ ашиглан суралцагчид хичээр нөлөөлөхийг завдах, нолоолех, үзэл бодлоо тулгах, бүдүүлэг уг хэллэгээр загнах, нэр хоч өгөх, биээ авч яваа байдал, хувцаслалт, хувийн амьдралын талаар шүүмжлэх, дүгнэлт өгөх;
- Суралцагчийг хүйсээр ялгаварлах, айлган сурдүүлэх, дарамтлах, хонзогнох;
- Өөрийн үйлдлийг хөнгөвчлөх зорилгоор хэлбэрдэх, мэргэжлийн үйл ажиллагаанд захидаж хийнга хандах, үншиж шалгаагүй ажилд үнэлгээ өгч дүн тавих;
- Суралцагчийн суралцах үйл ажиллагаанд саад учруулах зэрэг
- Сургуулийн орчинд худалдаа наймаа хийх, элдэв ном, гарын авлага, бараа бүтээгдэхүүн сурталчилах, шахах, тэдгээрийг худалдан авах, суралцагчийг ном худалдан авсан үгүйгээр нь ялгаатай хандах зэрэг;
- Сургалтанд ашиглах ном сурах бичиг, лекц, дадлагын хичээлийн агуулгад ативаа нэгэн арилжааны компанийн эм, эмнэлгийн хэрэгслэл, бараа бүтээгдэхүүний илт дэмжин сурталчилж бусдад давуу эрх олгохыг ёс зүйн зохицгүй үйлдэл гэж тооцно.

3.3. Эрдэм судалын ажлын хүрээнд, багш ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мөрдөнө. Уүнд:

- Судалгаа шинжилгээний ажлын арга зүй, мэдлэг, чадвараа байнга дээшилүүлэх;
- Өөрийн үзэл бодол, байр суурь, хандлагад анхааралтай хандах, хүлээх;
- Залуу багш, судлаач, суралцагчийн судалгаа шинжилгээний ажлыг дэмжих, туслалцаа үзүүлэх;
- Суралцагчийн судалгаа шинжилгээний ажлыг бодитой, шударга үнэлэх, үпон зөв дүгнэлт гаргах;
- Судлаачийг судалгаа шинжилгээний ажилд үнэлэлт дүгнэлт өгөхдөө хувийн харилцаа болон ашиг сонирхолын үүдиэс хандахгүй байх;

3.4. Эрдэм судалын ажлын хүрээнд, АШУУИС-ийн Багшийг ёс суртахууны зорчил гаргасанд тооцож, хариуцлага тооцох үндэслэл болох тохиолдлууд:

- Бусдын зохиол, бүтээл, судалгааны ажил, нээлтийг өөрийн болгож харуулахыг оролдох, хуулбарлах, зөвшөөрэлгүй ашиглах;
- Хамтын бүтээлийг өөрөө ганцаараа хийсэн болгож илэрхийлэх;
- Судалгааны үр дүнг девийлгэх, үнэн байдлыг гүйвуулах;
- Урьд хэвлүүлсэн зохиол бүтээлээ шинэ бүтээл болгож үнэлүүлэх;
- Намчирхах, улс төржих, үзэл суртлын байр сууриниас хандах зэрэг
- Бусдын хийсэн ном, сургалтын материал, гарын авлага, судалгаа шинжилгээний ажилд хүчээр оролцох, нэрээ оруулахыг тулгах;

3.5. Нийгэмд үлчлэх хүрээнд, багш ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мөрдөнө. Уүнд:

- Улс, нийгэм, сургуулийн хамт олны өмнө тулгарч буй асуудалд мэргэжлийн байр сууриниас ажил хэрэгч, бүтээлч, санаачилгатай, хэтийг бодож бууртай хандах, олны эрх ашигт нийцсэн голч санал дэвшүүлэх;

2. Мэргэжлийн мэдлэг, чадвар, судалгааны ажлын үр дүнг нийтэд мэдэгдэх, түгэн долгэрүүлэх, иштрүүлэхдээ хүнзэг, жудагтай байх;
3. Нийгэмд бодитой, үнэн, үндэслэлтэй мэдээлэл хүргэх;
4. Бусдын мэргэжлийн шүүмж, санал, дүгнэлтийг хүлээж авах;
5. Багшийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагын талаар тодорхой мэдлэгтэй байх, түүнийг бүрэн хүлээн зөвшөөрөх, дэмжих, биелүүлэх;

3.6. Нийгэмд үйлчлэх хүрээнд, АШҮҮИС-ийн Багшийг ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, хариуцлага хүлээлгэх үндэслэл болох тохиолдлууд:

1. Сургуулийн болон багшийн нэрээр хувийн ашиг хонжоо олох;
2. Сургуулийн талаар бодитой бус, худал хуурмаг, үндэслэлгүй мэдээлэл тараах;
3. Шан харамж, авилга авах зэрэг

3.7. Суралцагчтай харилцахдаа Багши нь ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мордоно. Үүнд:

1. Суралцагчийн эрдэм мэдлэгт хандах идэвх санаачилгыг дэмжин өрнүүлэх, сургалтын үйл ажиллагааны хамтран зутгэгч гэж үзэх, хундэтгэх;
2. Харилцааны соёлтой, харилцааны ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрддөг иргэн болж төлөвшиход нь чин сэтгэлээс туслах;

3.8. Суралцагчтай харилцахдаа, АШҮҮИС-ийн Багшийг ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, хариуцлага хүлээлгэх үндэслэл болох тохиолдлууд:

1. Суралцагчидад сэтгэл зүйн дарамт үзүүлэх, ичээж зовоосон, гутааж доромжилсон үг хэлэх, үйлдэл хийх;
2. Хувийн зорилго, эрх ашигийн төлөө суралцагчийн хөдөлмөрийг ашиглах;
3. Суралцагчидад бэлгийн дарамт үзүүлэх, оролдох, үйлдэх;
4. Суралцагчаас болэг, шан харамж, авилга авах;
5. Багшийн байр суурийн давуу байдлыг ашиглан суралцагчид дарамт шахалт үзүүлэх;
6. Муу дүн тавихаар суралцагчийг сүрдүүлэх, хавчиж гадуурхах;
7. Мэргэжлийн үйл ажиллагшаны явцад олж авсан суралцагчийн талаарх мэдээллийг бусдад задруулах

3.9. АШҮҮИС-ийн Багши нь хамт олонтойгоо харилцахдаа ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мөрднө. Үүнд:

1. Багши нь хамт олонтойгоо харилцахдаа нас хүйс, яс үндэс, нийгмийн гарал угсаа, шашин шүүтэгээр ялгаварлалгүй, адил тэгш, хүндэтгэлтэй, зөв боловсон, үнэнч шударга, уян хатан, харилцах;
2. Бусдын үйл ажиллаганаа, бүтээл, мэдлэг, чадварт үнэлгээ өгөх, үг, шуумж хэлэхдээ шударга, голч, бодитой хандах;
3. Урьд өмнө үүссэн үзэл бодлын ялгаа, зөрүүтэй байдал, тухайн ажилд үл хамаарах зөрчил маргаан, санал нийлэхгүй үр дүнгээс ангид байх;

3.10. Хамт олонтой харилцахдаа, АШҮҮИС-ийн Багшийг ёс суртахууны зөрчил гаргасанд тооцож, хариуцлага хүлээлгэх үндэслэл болох тохиолдлууд:

1. Хамтран ажиллагчийн мэдлэг, чадварын талаар санаатайгаар худал мэдээлэх;
2. Боловсрол болон бусад зохих шалгуураар тэнцэхгүй хүнийг ажилд ороход нь туслах, шан харамж амлуулах, авах;
3. Мэргэжил, мэргэшлийн мэдлэг, чадвартай холбоотой материалыа нуун дарагдуулах, худал мэдээлэх;
4. Мэргэжлийн болон хөдөлмөрийг үнэлж дүгнэх дүрэм, журам, үйл ажиллагаатай шууд холбоогүй шалгуураар багшийн мэргэжлийн чадварыг үнэлэх;
5. Багши, ажилтны талаар санал өгөхдөө хувийн хандлага, харилцаа, үнэлгээнд тулгуурлах;
6. Шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчил гаргах;

7. Бусдыг хилсээр буруутгах, мэдээллийг гүйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээлэх, хувийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах;
8. Сургуулийн иорийн өмнөөс хувьдаа болон дотно харилцаатай, сонирхол бүхий эргээд шууд ба шууд бусаар олз ашиг олох ажил хэрэг сэдэх, зохион байгуулах, оролцох, сайшааж дэмжих;
9. Шинээр ажилд орж байгаа болон ажиллаж байгаа багш, ажилтныг албан тушаал, зэрэг, зэрэглэл, бусад давуу байдлаа ашиглан дарамтлах, бүлэглэн шахаж хавчихыг санаачлах, зохион байгуулах, оролцох;
10. Сургуулиас санаачилсан болон ивээн тэтгээн үйл ажиллагааг санаатай таслах, тасалдуулах;
11. Багш, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, заналхийлэх, дарамтлах;
12. Хов жив хөөцөлдөх, бусдыг хутган үймүүлэх, гутгэх, муучилж доромжлох, өөлж шоолох зэргээр зүй бусаар авирлах;
13. Амин хувии хичээх, өөрийгөө ихэд бодох, өөрийн эрх ашгийг хамт олныхоос дээгүүр тавих, олны хэргээс хойш суух зэрэг

Доров. Удирдах ажилтан болон захиргаа, уйлчилгээний ажилтны баримтлах ёс суртахууны хэм хэмжээ

4.1. Удирдах болон бусад ажилтан нь ажил үүргээ биелүүлэхтэй холбоотой ёс суртахууны дараах ийтлэг хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

1. Үүрэгт ажлаа хариуцлагатай, идэвх санаачилгатай, үнэнчээр гүйцэтгэх;
2. Ажлын цагийг чанд баримтлах, үр өгөөжтэй, бүтээлч ажиллах;
3. Багш, ажилтан, суралцагчдыг шаардлагатай мэдээллээр түргэн шуурхай, нээлттэй, ил тод, тогтмол хангах;
4. Багш, ажилтан, суралцагчийн болон сонирхлын бүлгүүдийн санал, хүсэлт, шаардлагад бодитой, үндэслэлтэй, тэгш, шударга ханцах, шийдвэрлэх;
5. Албан болон хувийн харилцааг чанд зааглах, сургууль, хамт олны эрх ашгийг хувийнхаас ямагт дээгүүр тавих;

4.2. Удирдах болон бусад ажилтны дараах зорчлийн тохиолдлуудыг ажил үүрэгтэй холбоотой ёс суртахууны ийтлэг хэм хэмжээг зөрчсон тооцож, хариуцлага тооцох үндэслэл болгон. Үүнд:

1. Үүрэгт, албан ажлаа хувийн ашиг сонирхолоор гүйцэтгэх;
2. Сургуулийн иэрээр хувийн ашиг хонжоо хөөцөлдөх, хувьдаа ашиг завшаан олох;
3. Хувийн ашиг сонирхлын үүднээс сурталчилгаа хийх, мэдээлэл тараах, зөвшөөрөлт олгох, шийдвэр гаргах;
4. Албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглах, материаллаг болон материаллаг бус байдлаар шан харамж авах, өгөхийг шаардах;
5. Багш, ажилтны ажил байдлын үнэлгээ, санал асуулгын үр дүн, суралцагчийн сурлагын дунд нелөөлөх үйлдэл, эс үйлдэл хийх, завдах;
6. Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж ойр дотны харилцаатай хүмүүст давуу боломж олгох, дэмжлэг үзүүлэх;
7. Боловсон хүчинийг ажилд авах, томилох, албан тушаал дэвшүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх зэрэгт ашиг сонирхлын зөрчил гаргах;
8. Ажлын цагаар хувийн шинжктэй зүйл ярих, хувийн асуудал хөөцөлдөх;
9. Ашиг сонирхлын зорчилтэй шийдвэр гаргах, тулгах;

4.3. Удирдах ажилтан нь ажил үүргээ биелүүлэхтэй холбоотой ёс суртахууны тусгай хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

1. Боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай, хариуцлагатай оролцох, манлайлагч байх;

- Сургуулийн стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулахад идэвх санаачилгатай оролцох, хэрэгжилт, явц, үр дүнд тогтмол хяналт тавьж ажиллах зэргээр ажлын чиг үүрэг, хүлээн зөвшөөрсөн ажлын байрийн тодорхойлолтыг чанд мөрдех;
- Сургалт, эрдэм шинжилгээний ажлын түвшинг орчин үеийн шаардлагад нийцүүлэн ажиллах;
- Аливаа шийдвэрийг гаргахдаа сургууль, хамт олны эрх ашгийн үүднээс үндэслэлтэй, зүй зохицтой, хууль, дүрэм, журамд нийцүүлэх, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэнд байнга хяналт тавих;
- Ойр дотны харилцаатай хүмүүсийн үйл ажиллагаа, шийдвэр нь ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүйд анхаарч ажиллах;
- Сургуулийн окоуны емчид оруулах алив хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамт олонд ашиг тустай эрдэм судлалын ажлыг ивээн тэтгэгчтэй идэвхтэй хамтран ажиллах;

4.4. Удирдах ажилтны ажил үүргээ билүүлэхтэй холбогдох тусгай хэм хэмжээний зөрчлүүд, хариуцлага хүлээх үндэслэлүүд:

- Сургуулийн емч хөрөнгө, неөцийг улс төрийн нам, хүч, улстөрч, сонгуульд нэр дэвшигчид хандивлах;
- Эрх мэдэл, албан тушаал, нөлөөллөө зүй бусаар урвуулан ашиглах;
- Сургуулийн емч хөрөнгөд хор, хохирол учруулах;
- Гэрээ, хэлцэл байгуулахдаа хувийн ашиг сонирхлыг тусгах, хувьдаа ашиг хонжкоо хайх;
- Сургуулийн иорийг барьж хувьдаа болон дотно харилцаатай, сонирхол бүхий этгээдэд ашиг хонжкоотой ажил хэргийг шууд болон шууд бусаар гэрээлэх, даалтаж, сэдэх, зохион байгуулах, шийдвэр гаргах зэрэг

4.5. Ажилтны ажил үүргээ билүүлэхтэй холбоотой баримтлах ёс суртахууны тусгай хэм хэмжээг дараах байдлаар томъёолно. Үүнд:

- Ажил үүрэгтэй холбоотой мэдээлэл олж авах боломжийг тогтоосон эрх хэмжээнил нийцүүлэн исэлтэй байлагах;
- Сургуулийн удирдлага, багш, ажилтан ажилчийн, суралшагчдаа холбогдох үйлчилгээг түргэн шуурхай, чирэгэлгүй, чанартай, тэгш хүртээмжтэй, төлөвлөсөн хугацаанд нь хүргэх;
- Сургуулийн эд хогшил, техник хөргөсөл, тоног тохиромж, сургалтын хэргэсэл, хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу зүй зохицтой, ариг гамтай эдлэх, зарцуулах зэргээр холбогдох дүрэм, журамд зааснаар эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх;
- Ажлын цагийг үр бүтээлтэй, зохицтой ашиглах, ёгсен үүрэг даалгаврыг цаг тухайд нь хугацаанд нь чанартай гүйцэтгэх;

4.6. Удирдах ажилтан болон бусад ажилтан нь албан харилцаатай холбоотой ёс суртахууны дараах хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

- Албан тушаал, нас хүйс, яс үндэс, нийгмийн гарал угсаа, шашин шүтлэгийг үл харгалзан бие биетэйгээ шударга, хүндэтгэлтэй, зөв боловсон харилцах;
- Багаар ажиллахдаа бусдыгаа хүндэтгэх үүднээс цаг чанд барих;
- Багаар ажиллахдаа үзэл бодлын ялгаа, зөрүү, тухайн ажил хэрэгт үл хамаарах маргаан зөрчил, санал зерелдээн, сэтгэл нийлэмжгүй байдлаас ангид байх, олны эрх ашгийг эн тэргүүнд тавих, цөөнхийн саналыг хүндэтгэх;
- Багш, ажилтан, суралшагч, сонирхлын бүлгийн гишүүдэд зөлдэг, соёлч боловсон, хөнгөн шуурхай, тэгш, хүртээмжтэй үйлчлэх зэрэг

4.7. Удирдах ажилтан болон бусад ажилтныг гаргасан дараах зөрчлүүдийг албан харилцаатай холбоотой ёс суртахууны зөрчлийн тохиолдолд тооочон, хариуцлага хүлээх үндэслэл гэж үзүүлж. Үүнд:

- Мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан багш, ажилтан, суралшагчийн ажил хэргийн болон хувийн нууцтай холбоотой мэдээллийг бусдад задруулах;
- Хувийн зорилго, эрх ашгийн үүднээс суралшагчийн хөдөлмөрийг завших;

3. Мэргжлийн шийдвэр, үйлдэлд нөлоолохүйц бэлэг, шан харамж авах, өгөхийг шаардах, тулгах, дарамтлах, завдах;
4. Байр суурийн давуу байдлыг зүй бусаар ашиглах;
5. Бусдын иэр төр, байр суурийг гутсаах, албан тушаал дэвших, нэр алдар хүртэх, шагнал урамшуулал авах боломжийг нь хаах, саад учруулах зэрэг

Тав. Суралцагчийн дагаж мордох ёс суртахууны хэм хэмжээ

5.1. Суралцагч суралцах үйл ажиллагаанд баримтлах ёс суртахууны хэм хэмжээг дараах байдлаар томъёлон ойлгож, дагаж мөрдвлэл зохино. Үүнд:

1. Эрдэм, мэдлэгийг эрхэм болгох, өөрийгөө ямагт боловсруулан хөгжүүлэх, сурлагадаа байнга ахиц дэвшил гаргах;
2. Сургуулиас батлан гаргасан суралцагчийн дурэм, журмыг уншиж судласан байх, чанд дагаж мөрдөх;
3. Хичээлийн хетөлбөр, төлөвлөгөө, хуваарь, цагийг баримтлах, хичээл, дадлагын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;
4. Хичээлийн цагийг зүй зохистой үр бүтгэлтэй ашиглах;
5. Даалгавар, ангийн болон бие дааж хийх ажлыг чанартай, хугацаанд нь гүйцэтгэх;
6. Сургуулийн омч хөрөнгийг /анги танхим, гудамж, хаалга цонх, эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн, ном суралцах бичиг, гарын авлага, диплом, сонин, сэтгүүл, компьютер, техник хэрэгсэл гэх мэт/ ариг гамтай, зориулалтаар нь эдэлж хэрэглэх, ашиглах;
7. Улирлын болон улсын шалгалт, бусад шалгалт, тестийн журмыг чанд сахиж мордох;
8. Эмнэл зүйн баз эмнэлгүүдэд хичээлийн суралцагсад үед тухайн эмнэлгийн дотоод дурэм, сургуулийн сэйлын хэм хэмжээг чанд мөрдэн багшийн удирдлагын дагуу сургалт эмнэл зүйн үйл ажиллагаанд хамрагдана.

5.2. Суралцагчийн суралцах үйл ажиллагаанд гаргасан ёс суртахууны зөрчлийн тохиолдуул, хариуцлага тооцох үндэслэлүүд:

1. Өнрийгөө болон бусдыг хуурч мэхлэн үнэнд үл нийцэн үнэлгээ авах, завдах;
2. Хүндэтгэх шалтгаа шүгүүгээр хичээл таслах, хожимдох, хичээлийн дундуур гарч, орох;
3. Хичээлийн цагаар багшийн сургах, суралцагчийн суралцах үйл ажиллагаанд саад учруулах, хичээлийн хэвийн ажиллагааг алдагдуулах /тар утсаар ярих, мессеж бичих, тоглоом тоглох, цахим хэрэгслийг хичээлийн бус зориулалтаар ашиглах, бохь зажилах, хогжим сонсох, чанга дуу гаргах, ярих, инээх зэрэг/;
4. Сургалтын материалыг бусдаас хуулах, зовхон өөрөө ашиглах зорилгоор шууж дарагдуулах, өөрчлох зэргээр бусадтай шударга бусаар өрсөлдөх;
5. Хичээлийн даалгавар, бие дааж гүйцэтгэх ажилдаа бусдын хийснийг хэсэгчлэн болон бүтийн хуулан оруулах, санааг нь зөвшөөрөлгүй, иш таталгүй, эх сурвалжийг дурьдалгүй ашиглах зэргээр хууран мэхлэх;
6. Шалгуулж үнэлгээ авсан ажлыг дахин ашиглаж давхар үнэлүүлэх;
7. Багшийн өгсөн дүн, оноог засах, үнэлгээг өөрчлөх;
8. Бусдын өмнөөс шалгант өгөх, бусдыг өөрийн өмнөөс шалгальтанд оруулах;
9. Шалгалтын журам зөрчих, шалгалтын үед бусдад мэдээлэл өгөх, авах, бусдын болон өөрийн авч ирсэн материал хуулах, хориглосон /тар утас, цахим төхөөрөмж гэх мэт/ хэрэгсэл ашиглах;
10. Хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл таслах, үүнийгээ нуун дарагдуулах зорилгоор хуурамч баримт бичиг бүрдүүлэх;

5.3. Суралцагч суралцах үйл ажиллагаанаас бусад хүрээнд ёс суртахууны дараах хэм хэмжээг морлоне. Үүнд:

1. Сургуулийн эрхэм зорилгыг сайтар мэддэг, ухамсарласан, дээдлэн хүндэтгэдэг байх;
2. Сургуулийн хичээлийн болон өюутны байр, хонгил, анги танхим, номын сан, биений тамирын заал, бие дааж ажиллах төв, цахилгаан болон явган шат, сургуулийн орчны ногоон байгууламж зэрэг нийтийн эзэмшлийн байр, талбай, эл хөрөнгө, тоног төхөөрөмж,

- ус, цахилгаан, номын сангийн ном, сурах бичгийг ариг гамтай, зориулалтын дагуу ашиглах, зөв боловсон, зүй зохицтой үйлчлүүлэх,
3. Мэндлэх, хүндлэх ёсыг баримтлахыг эрмэлзэх;
 4. Сургуулийн эрх бүхий албан тушаалтан, багш, ажилтан, ажилчид болон суралцагчийн зүй ёсны шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
 5. Оюутны үүсгэл санаачилгаар байгуулсан клубт элсэх, ажиллах, клуб байгуулахыг санаачлах, удирдах;

5.4. Сургуулийн орчинд, суралцагчийн суралцах үйл ажиллагаанаас бусад хүрээнд гаргасан ёс суртахууны зорчилд тооцогдох тохиолдлууд, хариуцлага хүлээлгэх үндэслэл:

1. Сургуулийн орчинд холбогдох дотоод дүрэм, дэг журмыг зөрчих, үл хүндэтгэх /биеэ зөв авч явахгүй, хог хаях, бохирдуулах зэргээр/;
2. Орчин тойрныхоо хүмүүсийн үнэ цэнэ, нэр хүндийг үл хүндэтгэх, ялгаварлах, бүдүүлэг, шударга бус хандах, эрх ашигт нь хохирол учруулах, дарамт шахалт үзүүлэх, дайрч доромжлох, нэр төрийг нь сэвтүүлэх;
3. Компьютерийн служжээ, программд зүй бусаар нэвтрэх, бусдын код, нууц үгийг зүй бус аргаар мэдэх, ашиглах, техник хэрэгсэлийн жижиг эд ангийг солих, хулгайллах, эдгээрийг үйлдэхээр оролдох, завдах;
4. Хувийн үзэл болдоо сургуулийн байр суурь мэтээр ухуулан ойлгуулах, сургуулийн боллого, үйл ажиллагаа зэргийг гажуудуулан сурталчлах, худал ташаа мэдрэлэл бүхий зар сургалчилгаанд оролзох;
5. Сургуулийн орчин (хичээлийн байр, оюутны байр сургуулийн нутаг дэвсгэр)-д хөзөр, даалуу, компьютерийн тоглоом мөрийтэй тоглох, хэт чанга дуу авиа үүсгэх;
6. Сургуулийн анти танхим, албан тасалгаа, дотуур байранд зөвшөөрөлгүй нэвтрэх;
7. Сургуулийн орчинд согтууруулах ундаа, мансууруулах зэрэг сэтийцэд хортойгоор нолоюлох зүйл авч явах, хэрэглэх, хадгалах, эдгээрийг үйлдэхээр оролдох, завдах;

Зургаа. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт

6.1. Ёс зүйн дүрмийн зорчлийн тохиолдол бүрт багш, удирдах ажилтан болон бусад ажилтан, суралцагчдал дараах эх сурвалжийг үндэслэн энэхүү Ёс зүйн дүрмийн дагуу, зорчил гаргасан эсэхийг нь тогтооно. Үүнд:

1. Суралшагч, багш, удирдах ажилтан, ажилтан, сонирхлын бүлгийн гишүүн, үйлчлүүлэгчдээс бичгээр ирүүлсэн мэдээлэл;
2. Сургуулийн албад, тэнхмүүдээс ирүүлсэн мэдээлэл, хэлэлцээн хурлын протокол, санал дүгнэлт, шийдвэр;
3. Хууль хяналтын байгууллагын албан ёсны шийдвэр, мэдээлэл;
4. Сургуулиас зохион байгуулсан төрөл бүрийн санал асуулгын дүн;
5. Ёс суртахууны зорчил гаргасан талаарх багш, удирдах болон бусад ажилтны мэдэгдэл, тайлбар;
6. Бусад холбогдох мэдээлэл;

6.2. Ёс зүйн дүрэм зөрчсон этгээдэд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын болон Дээд Боловсролын тухай Монгол Улсын хуулиуд, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан дүрэм, журам, тушаал шийдвэр, АШУҮИС-ийн Хөдөлмөрийн Дотоод Журам, АШУҮИС-ийн бүрэлдэхүүний сургууль, салбар сургуулийн багшийн мэргэжлийн ёс зүйн дүром, бусад ёс зүйн баримт бичиг болон энэхүү Ёс зүйн дүрмийн дагуу, зорчлийн хор уршиг, хохирол, хэмжээг харгалзан сахилга хариуцлагын дараах шийтгэл ногдуулна. Үүнд:

1. Эхний удаад багш, удирдах ажилтан, ажилтанд авах сахилгын шийтгэлийг АШУҮИС-ийн Хөдөлмөрийн Дотоод Журамд зааснаар ногдуулна.
2. Зорчлийн тохиолдлыг давтан гаргасан багш, удирдах ажилтан болон бусад ажилтны албан тушаалын зэрэглэлийг гурав хүртэл сарын хугацаатай бууруулах сахилгын шийтгэл оноож болно.

3. Зөрчлийг удаа дараа гаргасан, өмнөх сахилгын шийтгэлийн хүчинтэй хугацаа дуусаагүй байхад зорчил гаргасан, эсвэл ноцтой, хүндүүлэн үзэх зорчил гаргасан бол АШҮҮИС-ийн Хөдөлмөрийн Дотоод Журамд заасан сахилгын шийтгэлийг шат алгасуулан ногдуулах буюу ажлаас халах хүргэл арга хэмжээ авна.

4. Ёс зүйн дүрмийн зорчил гаргасан суралцагч оюутанд эхний удаад амаар болон бичгээр сануулна.

5. Сануулах шийтгэл хүлээсэн хугацаандaa ёс суртахууны зорчил дахин гаргасан суралцагчид, суралцагч байх эрхийг нь хасахыг заавал бичгээр сануулна.

6. Ёс суртахууны зорчил удаа дараа гаргаж, өмнөх арга хэмжээнд засраагүй болон ёс суртахууны ноцтой зорчил гаргасан суралцагчийн суралцах эрхийг нь хасч, нийтэд мэдээлнэ.

6.3. Ёс суртахууны зорчил гаргасан суралцагчид сахилга хариуцлагын шийтгэл ногдуулахаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Нэг хичээлийн улирлын хугацаанд нэгзэс илүү удаа ёс суртахууны хариуцлага ногдуулахгүй.

2. Суралцах эрхээ хасуулсан этгээдийн сургалтын төлбөрийг нь буцааж олгохгүй /Энэ тухай Оюутны төлбөр тооцоо хийх тухай журамд бий/.

3. Энэ дүрэмд ёс суртахууны зорчил гэж заасан үйлдлүүдийг мэдээгүй нь суралцагч хариуцлагаас мултрах үндэслэл болохгүй.

6.4. Сургуулийн хэмжээнд ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дараах институции хангаж, хянаж ажиллана. Үүнд:

1. Захирал

2. Ёс Зүйн Хороо

3. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд

4. Санал Гомдлын Хороо

5. ЗХШУА-ны дарга

6. СБЗГ-ын дарга

7. Оюутны албаны декан

8. Хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүйч

9. Дотоод Аудитор

6.5. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт дэх Захирлын үүрэг:

1. АШҮҮИС-ийн Соёлын стандарт, түүний хавсралтууд, ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт, засвар оруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар чиглэл, удирдамж огох, сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт тусгах, хяналт тавих;

2. Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, ёс суртахууны хэм хэмжээг сахиуулан морлуулэхтэй холбоотой тушаал гаргах;

3. Ёс суртахууны зорчил гаргагчид сахилга хариуцлагын шийтгэл хүлээлгэх тушаалыг ёс зүйн хорооны шийдвэрийг үндэслэн гаргах, хяналт тавих;

4. Ёс Зүйн Хорооны гишүүнээр ажиллуулах багш, ажилтны төлөөлөл 1-2 хүнийг нэр дэвшүүлэх

5. АШҮҮИС-ийн ёс Зүйн Хорооны дүрмийг батлах

6. Ёс Зүйн Хорооны хуралд таслах эрхгүй оролцох, ажиглах зэрэг

6.6. АШҮҮИС-ийн ёс Зүйн Хороо нь өөрийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ АШҮҮИС-ийн Соёлын Стандарт, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дараах үүрэгтэй ажиллана. Үүнд:

1. Энэхүү стандартыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох асуудлаар сургуулийн захиралд зөвлөх, судлах, шинжлэх, нийт багш, суралцагч, ажилтанд ухуулах, таниулах, албан шаардлага тавих;;

2. Багш, ажилтан, суралцагч оюутны ёс суртахууны зорчил гаргасан эсэхийг тогтоосон Санал Гомдлын Хорооны анхан шатны санал дүгнэлтийг хэлэлцэн, холбогдох Монгол Улсын

хууль, тогтоол шийдвэр, АШҮҮИС-ний дүрэм, журам, стандарт, Ёс зүйн дүрмийн хүрээнд нягтлан магадлах, дүгнэлт гаргах;

3. Ёс суртахууны зорчил гаргагчид сахилга хариушлагын шийтгэл ногдуулах эсэхийг шийдвэрлэх санал гаргах;
4. Ёс суртахууны зорчил гаргагчид ногдуулах ёс суртахууны сахилга хариушлагын шийтэлийн зэрэг хэмжээг тогтоох санал гаргах;
5. Ёс суртахууны зорчил гаргагчид сахилга хариушлагын шийтгэл ногдуулах санал гаргах;

6.7. Санал Гомдлын Хороо нь өөрийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ энхүү Соёлын Стандарт, Ёс зүйн дүрэмд дараах чиг үүрэгтэй оролцож ажиллана :

1. Багш, ажилтан, суралцагч оюутны ёс зүй, ёс суртахууны зорчлийн тохиолдол бурийн тухай энхүү дүрмийн 6.1-д заасан эх сурвалжийн мэдээлэл, баримтыг хүлээн авах, бүртгэх, ангилах
2. Санал Гомдлын Хорооны хурлаар ирсэн мэдээллийг нягтлан хэлэлцэж, зорчил гаргасан этгээдэд сахилгын хариушлагын шийтгэл оноох эсэх анхан шатны саналыг Ёс Зүйн Хороонд уламжлан, бичгээр хүргүүлнэ.

6.8. Санал гомдлын хороо дараах бүрэлдэхүүнтэй байна.

- | | | |
|---|---|------------------------------|
| 1. Захиргаа хяналт шинжилгээ үзүүлгээний албаны дарга | → | Санал гомдлын хорооны дарга |
| 2. Дотоод аудитор | → | Санал гомдлын хорооны /НБД/ |
| 3. Хяналт шинжилгээ, үзүүлгээний арга зүйч | → | Санал гомдлын хорооны гишүүн |
| 4. Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга | → | Санал гомдлын хорооны гишүүн |
| 5. Оюутны албаны декан | → | Санал гомдлын хорооны гишүүн |
| 6. Хамт олны төлөөлөл | → | Санал гомдлын хорооны гишүүн |
| 7. Оюутны холбооны толоолол | → | Санал гомдлын хорооны гишүүн |

6.9. Хяналт шинжилгээ, үзүүлгээний арга зүйч, Дотоод Аудитор нар нь өөрийн ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод зааснаас гадна Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ажиглах, шаардлага тавих, зорчлийн тохиолдлыг мэдээлэх, ёс зүй, ёс суртахууны зорчлийн тухай хэлэлцэх Санал Гомдлын Хорооны хуралд таслах эрхгүй оролцох үүрэг гүйцэтгэнэ.